БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/383 Булган сум

Сонгуулийн санал авах өдөр зарим үйл ажиллагааг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн санал авах өдөр 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Орхон суманд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг тус тус хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа (Л.Ганбаатар), Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

АБХЭ-everyday Doc/2022/Захирамж

6320220494